

МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙДЫН ТУШААЛ

2020 оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Журамд нэмэлт, өөрчлөлт
оруулах тухай

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.11 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/216 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Тамга, тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журам /цаашид “журам” гэх/”-ын 5, 8, 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 5.3, 8.4, 9.2 дахь хэсэг тус тус нэмсүгэй:

“5.3.Хяналтын дугаарын улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан үндэслэл арилсан тохиолдолд улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдлийг дахин гаргаж болно.”

“8.4.Улсын бүртгэгч энэ журмын 8.3-т заасан тамга, тэмдгийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын баталсан маягтаар ажлын 5 өдрийн дотор улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийн архивт хүлээлгэн өгнө.”

“9.2.Улсын бүртгэгч лавлагаа олгосон тухай баримт бичгийг сар бүр архивын хадгаламжийн нэгж болгон, дараа сарын 10-ны өдрийн дотор улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийн архивт хүлээлгэн өгнө.”

2.Журмын 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн “шүүгээнд” гэсний дараа “түр” гэж, 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн “болгон” гэсний дараа “, дараа сарын 20-ны өдрийн дотор” гэж тус тус нэмсүгэй.

3.Журмын дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/Нэгдүгээр зүйлийн 1.4 дэх хэсэг:

“1.4.Улсын бүртгэгч Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 8 дугаар зүйлийн 8.3-т заасан хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газар, гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газар, Засгийн газар хоорондын байгууллага, түүний төлөөлөгчийн газарт хяналтын дугаар олгоно.”

2/Нэгдүгээр зүйлийн 1.6 дахь хэсэг:

“1.6.Энэ журмын 1.4 дэх хэсэгт заасан этгээдийн тамга, тэмдэгт нэр, хэлбэр, регистрийн дугаар, тамга, тэмдгийн үйлдвэрийн код, хяналтын дугаарыг бичнэ.”

3/Хоёрдугаар зүйлийн 2.1.6 дахь заалт:

“2.1.6.хяналтын дугаарын улсын бүртгэл хөтлөхөд үндэслэсэн өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг тухай бүр цахимжуулан, тухайн хуулийн этгээдийн

хувийн хэрэгт хавсаргахаар ажлын 5 өдрийн дотор улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийн архивт шилжүүлэх;”

4/Дөрөвдүгээр зүйлийн 4.2.3, 4.2.6, 4.2.9, 4.2.10 дахь заалт:

“4.2.3.улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;”

“4.2.6.тамга, тэмдэг устсан, эсхүл хаяж үрэгдүүлсэн тохиолдолд хяналтын дугаарыг хүчингүйд тооцсон хяналтын улсын байцаагчийн дүгнэлт;”

“4.2.9.хяналтын дугаар бүхий маягтыг хаясан, үрэгдүүлсэн тохиолдолд хяналтын дугаарын улсын бүртгэлийг хүчингүйд тооцсон хяналтын улсын байцаагчийн дүгнэлт;”

“4.2.10.энэ журмын 4.1.1, 4.1.2, 4.1.3, 4.1.4-д заасан баримт бичиг.”

5/5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалт:

“5.1.3.хяналтын улсын байцаагчийн дүгнэлт, эсхүл эрх бүхий этгээдийн шийдвэрээр бүртгэлийг хүчингүй болгосон, улсын бүртгэлд хориг тавьсан /түдгэлзүүлсэн/;

6/Зургаадугаар зүйлийн 6.4 дэх хэсэг:

“6.4.Тамга, тэмдэг үйлдвэрлэх этгээд улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хуулийн этгээдийн улсын бүртгэл хариуцсан нэгжид тайланг цаасан болон цахим хэлбэрээр сар бүрийн сүүлийн ажлын өдрөөр тасалбар болгон гаргаж, дараа сарын 10-ны өдрийн дотор ирүүлэх бөгөөд тайланд үйлдвэрийн албан бичиг, үйлдвэрлэсэн тамга, тэмдгийн жагсаалт, хяналтын дугаар бүхий маягтын буцах хэсгийг хавсаргана.”

7/Наймдугаар зүйлийн 8.5 дахь хэсэг:

“8.5.Энэ журмын 8.4-т заасны дагуу архивт хүлээлгэн өгсөн тамга, тэмдгийг устгах ажлыг хагас жил тутамд нийслэлд улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын тушаалаар, аймагт тухайн аймаг дахь улсын бүртгэлийн хэлтсийн даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг зохион байгуулна.”

8/Ес дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг:

“9.1.Улсын бүртгэгч хураалгасан тамга, тэмдгийн тодорхойлолтыг тухай бүр цахимжуулан, тухайн хуулийн этгээдийн хувийн хэрэгт хавсаргахаар ажлын 5 өдрийн дотор улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийн архивт хүлээлгэн өгнө.”

4.Журмын 1 дүгээр зүйлийн 1.7 дахь хэсгийг “1.6” гэж, 5 дугаар зүйлийг “4 дүгээр” гэж, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг “4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг” гэж, мөн хэсгийн 5.1.5, 5.1.9, 5.1.10, 5.1.11 дэх заалтын дугаарыг “4.1.1, 4.1.2, 4.1.3, 4.1.4” гэж, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг “4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг” гэж, мөн хэсгийн 5.2.1-5.2.10 дахь заалтын дугаарыг “4.2.1-4.2.10” гэж, 6 дугаар зүйлийг “5 дугаар” гэж, 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь хэсгийг “ 5 дугаар зүйлийн 5.1. 5.2 дахь хэсэг” гэж, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 6.1.1-6.1.4 дэх заалтын дугаарыг “5.1.1-5.1.4” гэж, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн “6.1-д” гэснийг “5.1-д” гэж, 7 дугаар зүйлийг “6 дугаар” гэж, 7 дугаар зүйлийн 7.1-7.4 дэх хэсгийг “6.1-6.4” гэж, 8 дугаар зүйлийг “7 дугаар” гэж, 8 дугаар зүйлийн 8.1-8.3 дахь хэсгийг “7.1-7.3” гэж, 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн “7.4-

т” гэснийг “6.4-т” гэж, 9 дүгээр зүйлийг “8 дугаар” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3, 9.4, 9.5 дахь хэсгийг “8.1, 8.2, 8.3, 8.5, 8.6” гэж, 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “5.2.6, 5.2.7-д” гэснийг “4.2.6, 4.2.7-д” гэж, 8.6 дахь хэсгийн “9.4-т” гэснийг “8.5-д” гэж, 10 дугаар зүйлийг “9 дүгээр” гэж, 10 дугаар зүйлийн 10.1, 10.2 дахь хэсгийг “9.1, 9.3” гэж тус тус өөрчилсүгэй.

5.Журмын 1 дүгээр зүйлийн 1.8, 1.9 дэх хэсэг, 4 дүгээр зүйл, 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.2, 5.1.3, 5.1.4, 5.1.6, 5.1.7, 5.1.8 дахь заалт, мөн зүйлийн 5.3 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг